

Монгол Улсын Шадар сайдын
2014 оны дөрөв сарын 7-ны
өдрийн 21 дүгээр тушаалын
38-р хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН
АЛБАН ХААГЧИЙН ЖАГСААЛЫН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нэг. Жагсаал түүний элементүүд, жагсаалд
албан хаагчийн үүрэг

1. Жагсаал: онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид, /цаашид албан хаагч гэх/ Онцгой байдлын газар, хэлтэс, анги, отряд салбаруудыг /цаашид салбарууд гэх/ явганаар буюу машинтайгаар нэгтгэн ажиллуулахын тулд дүрэмд тогтоосноор байрлуулахыг хэлнэ;
2. Эгнээ: албан хаагч нь нэг нь нөгөөгийнхөө дэргэд нэг шугамд жагсахыг хэлнэ. Эгнээ жагсаалыг баруун /зүүн/ тийш эргүүлэхэд тэр нь цуваа жагсаал болно;
3. Үзүүр: жагсаалын баруун, зүүн төгсгөлийг хэлнэ;
4. Жагсаалын өвөр тал: жагссан албан хаагчдын нүүр хандсан талыг хэлнэ;
5. Жагсаалын ар тал: өвөр талын эсрэг талыг хэлнэ;
6. Жагсаалын өргөн: үзүүрүүдийн хоорондын хэмжээг хэлнэ;
7. Завсар: албан хаагчдын өвөр талын дагуух хоорондын хэмжээг хэлнэ;
8. Зай: албан хаагчдын гүн тийших хоорондын хэмжээг хэлнэ; Эгнээ хоорондын зай нь албан хаагчийн гар сунгам хэмжээтэй байх бөгөөд захирагч, дарга /цаашид захирагч гэх/-аас тусгайлан тогтоож болно.
9. Жагсаалын гүн: Нэгдүгээр эгнээнээс сүүлчийн эгнээ хүртэлх хэмжээг хэлнэ;
10. Хоёр эгнээ жагсаал: нэгдүгээр эгнээнд байгаа албан хаагчийн шилийг, хоёрдугаар эгнээнд байгаа албан хаагч харж, нэг алхам зайтай байрласныг хэлнэ;
11. Зэрэгцээ: албан хаагчид нэг нь нөгөөгийнхөө шилийг харж хоёр эгнээ жагсаалд жагсахыг хэлнэ; Эхний эгнээний албан хаагчийн шилийг харж зэрэгцэх хүн дараагийн эгнээнд нэгээр дутуу байвал түүнийг дутуу зэрэгцээ гэнэ. Сүүлийн зэрэгцээ дүүрэн байна. Хоёр

эгнээ жагсаалыг эргүүлэхэд дутуу зэрэгцээнд байсан албан хаагч урдах эгнээнд шилжиж орно.

12. Нэг буюу хоёр эгнээ жагсаал нь хураангуй буюу тараангуй байж болно.

Хураангуй жагсаал: албан хаагчид нэг нь нөгөөгөөсөө тохойн хооронд гарын алганы ергений хэмжээний завсартай жагсахыг хэлнэ;

Тараангуй жагсаал: албан хаагчид нэг нь нөгөөгөөсөө нэг алхам буюу захирагч /дарга/-аас тогтоосон хэмжээний завсартай жагсахыг хэлнэ;

13. Цуваа: албан хаагчид бие биеийнхээ шилийг харж дүрмээр буюу захирагч /дарга/-аас тогтоосон зай авч цувран жагсахыг хэлнэ;

Цуваа нь хэд ч байж болно. Анги, отряд, салбарууд (анги гэсэн ойлголтод Аврах тусгай, аврах, гал унтраах анги хамаарна) аяны буюу дэлгээ жагсаалаар жагсахдаа цувааг хэрэглэнэ.

14. Дэлгээ жагсаал: салбарууд нэг шугамд нэг буюу хоёр эгнээ, тэрчлэн дүрмээр буюу захирагч /дарга/-аас тогтоосон завсар авч цувааны шугамд жагсахыг хэлнэ;

Дэлгээ жагсаалыг үзлэг, шалгалт, ёслолын жагсаал болон бусад шаардлагатай үед хэрэглэнэ.

15. Аяны жагсаал: нэг буюу хэд хэдэн салбар цуваагаар жагсахыг хэлнэ;

16. Чиглүүлэгч: заасан чигт түрүүнд нь яваа албан хаагч (машин)-ийг хэлнэ;

Бусад албан хаагч (машин)-нь түүнтэй хөдөлгөөнөө тохируулна.

17. Цоожлогч: цувааны сүүлд яваа албан хаагч (машин)-ийг хэлнэ;

18. Захирагч /дарга/ жагсаалыг амаар болон дохиогоор тэрчлэн техник хэрэгслээр удирдана. Явган жагсаалд команд өгөхдөө захирагч өөрөө жагсаалын үндсэн зогсолтод шилжсэн байна. Цуваанд захирагч /дарга/-ийн дохиог салбарын дарга, машины ахлагч, томилогдсон хянагч нар дамжуулна. Дарга нь жагсаалыг удирдахад тохиромжтой газар байрлана. Бусад дарга нар дүрмээр буюу ахлах даргаас тогтоосон байрнаас команд дохиог дамжуулна. Аяны жагсаалд яваа салбар болон түүнээс дээших албан тушаалын захирагч /дарга/ зөвхөн команд өгөх, биелэлтийг нь шалгахаар жагсаалаас гарч болно.

19. Команд нь анхааруулах ба гийцэтгэх гэж байна. Зөвхөн гүйцэтгэх команд ч байж болно. Анхааруулах командыг захирагч /дарга/ жагсагчдаас ямар ажиллагааг шаардаж байгааг ойлгогдохоор тод, уртаар өгнө. Анхааруулах командаар жагсаалд буй албан хаагч үндсэн зогсолтод, хөдөлгөөнд байгаа нь жагсаалын алхаанд шилжиж, харин жагсаалын гадна байвал “Номхон” болж, нэрээ дуудахад захирагч /дарга/-ийн зигт эргэж зогсоно. Гүйцэтгэх командыг анхааруулах командын дараа чанга, огцом өгнө. Гүйцэтгэх командыг нэн даруй, зөв биелүүлнэ. Анхааруулах командад салбарын болон албан хаагчийн цол нэрийг зааж болно. Жишээ нь: “Салаа (бүлэг) - Зогс”, “Ахлагч Болд - Эргэ” гэх мэт. Команд өгч байгаа захирагч /дарга/-ийн дуу нь жагсаалын ергэн, гүний хэмжээнд тохирч байна.

20. Жагсаал болон машиныг тогтоосон дохиогоор удирдана. Салбарын дарга шаардлагатай бол жагсаал удирдах нэмэгдэл дохио тогтоож болно.

21. Бiх салбарт хамаарагдах команд (дохио)-ыг салбаруудын захирагч /дарга/, машины ахлагч нар хүлээн авч нэн даруй биелүүлнэ. Дохиогоор команд егэхдее урьдчилан “Анхаар” дохио егэх бөгөөд команд нь зөвхөн нэг салбарт хамааралтай бол уг салбарын дугаар заасан дохио егнэ. Дохиогоор команд хүлээн авахад бэлэн байгаагаа “Анхаар” дохиогоор хариулна. Дохиог хүлээн авсан нь түүнийг давтах буюу тохирох дохиог еерийн салбарт дамжуулснаар батлагдана.

22. Салбаруудыг “Жагс” командаар жагсаана. Жишээ нь: “Салаа (бүлэг) нэг эгнээ - Жагс” гэх мэт. Энэ командаар албан хаагч нь жагсаалд еерийн байрыг түргэн эзэлж, тогтоосон завсар зайг авч, жагсаалын үндсэн зогсолтоор зогсоно.

Хоёр. Жагсаалын өмнө, жагсаалд байгаа захирагч /дарга /
болон албан хаагчийн үүрэг

23. Захирагч /дарга/-ийн үүрэг:

23.1. жагссан салбаруудын бие бүрэлдэхүүн, техник, хэрэглэл, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болон багажийн тоог шалгаж мэдэх;

23.2. хэзээ, хаана, ямар хувцас хэрэглэлтэй жагсах, тэдний гадаад үзэмж, тоног хэрэглэлийн бүрдэл, биедээ тохируулж зүүсэн байдлыг шалгах;

23.3. бие бүрэлдэхүүнээр жагсаалын сахилгыг чанд сахиулах, салбарууд, албан хаагчаас команд (дохио)-ыг зөв биелүүлэхийг шаардах;

23.4. салбаруудын техник, хэрэглэлтэй жагсах үед тэдгээрийн гадаад байдалд үзлэг хийж, тэрчлэн бие бүрэлдэхүүнийг тээвэрлэх хэрэгслийн тоо, бүрэн бүтэн байдал, чиргүүл (техник, хэрэглэл)-ийн бэхэлгээ, эд хэрэгслийн ачилтыг шалгах, бие бүрэлдэхүүнд замын хөдөлгөөний болон аюулгүй ажиллагааны дүрмийг сахин биелүүлэхэд тавигдах шаардлагыг танилцуулж мөрдүүлэх.

24. Албан хаагчийн үүрэг:

24.1. захирагч /дарга/-аас заасан дүрэмт хувцас, хариуцуулж өгсөн техник, хэрэглэл, багаж хэрэгслийг бүрэн авч жагсах;

24.2. дүрэмт хувцас өмсөх журмын дагуу хувцаслаж, хувцас, хэрэглэлээ биедээ тохируулахад нь нөхөртөө туслах;

24.3. жагсаалд еерийн байраа мэдэж, түүнийг түргэн эзлэх, хөдөлгөөн үйлдэх үед зэрэгцээ, тогтоогдсон завсар зайг барих, жагсаалаас зөвшөөрөлгүй гарахгүй байх;

24.4. техник, тоног хэрэглэлтэй жагсах үед замын хөдөлгөөний болон аюулгүй ажиллагааны дүрмийг сахин биелүүлэх;

24.5. жагсаалд зөвшөөрөлгүйгээр ярихгүй байж, захирагч /дарга/-аас өгсөн команд (дохио)-ыг анхааралтай хүлээн авч, бусдад саад бололгүй хурдан, зөв биелүүлэх;

24.6. өгөгдсөн команд (дохио)-ыг шаардлагатай үед тод чанга дугаар зөв дамжуулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гурав. Жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн,
жагсаалын зогсолт

1. Албан хаагчид “ЖАГС” командаар түргэн жагсаж, “Номхон” командаар жагсаалын үндсэн зогсолт /зураг 1/-д шилжинэ. “Номхон” командаар албан хаагчид биеэ хүчлэлгүйгээр цэх зогсож, өсгийгөө нийлүүлэн өлмийн хооронд гутлын улны өргөний хэмжээтэй завсар авч өлмийгөө зэрэгцүүлэн зогсоно. Хөлөө өвдгөөрөө шулуун болгож, цээж гарган, их биеийг ялимгүй урагшлуулан, гэдсээ татаж, мөрөө

тэлнэ. Гараа хагас атгаж, доош нь чөлөөтэй унжуулан алгыг дотогш харуулж гуяны дунд хэсэгт байлган толгойг эгцлэн чигээрээ харж, дараагийн ажиллагааг биелүүлэхэд бэлэн болно. Албан хаагч тушаал өгөх буюу авах, илтгэл өгөх, түүнчлэн терийн дуулал эгшиглэх, ёслол гүйцэтгэх үед байран дээрээ командгүйгээр жагсаалын үндсэн зогсолтод шилжилнэ.

2. “Болно” командаар байран дээрээ зүүн хөлийг мөрний хэмжээтэй салгаж, хоёр гараа ардаа авч, зүүн гараар баруун гарны ардаас атгаж, биеийн жинг хоёр хөл дээрээ тэнцүүлэн зогсоно. /зураг 2/

“Болно **ЗАС**” командаар “Болно” командтай байгаа үед үндсэн зогсолтод шилжиж, байран дээрээ хувцас хэрэглэлээ засна.

Жагсаалаас гарах шаардлага гарвал жагсаал командалж байгаа захирагч /дарга/-аас зөвшөөрөл авна.

3. Малгай авхуулахын тулд “**Малгай-АВ**”, өмсүүлэхэд “**Малгай-ӨМС**” команд өгнө. Малгайг баруун гараар авч зүүн гарын тохойг нугалан шуун дэрээ тавьж, тэмдгийг урагш харуулан барина. /Зураг 3/

Байран дээрх эргэлт

4. Байран дээрх эргэлтийг “**Баруун (зүүн) тийш-ЭРГЭ**”, “**ЭРГЭ**” командаар гүйцэтгэнэ. Эргэлт болон зүүн тийш эргэх эргэлтийг зүүн хелийн есгий, баруун хелийн елмий дээр зүүн гар тийш, баруун тийш эргэх эргэлтийг баруун хелийн есгий, зүүн хелийн елмий дээр баруун гар тийш тус тус гүйцэтгэнэ. Эргэлтийг гүйцэтгэхдээ их биеийн цэх байдлыг алдалгүй, хөлөө өвдгөөр нь нугалахгүй биеийн жинг урд хөл дээрээ шилжүүлэн эргэж, нөгөө хөлөө дөт замаар татаж хавсарна. Эргэлтийн үед гарыг биенээс салгахгүй.

Хөдөлгөөн

5. Хөдөлгөөнийг алхаа буюу гүйлтээр үйлдэнэ. Алхалтын хурд минутад 110-120 алхам, хэмжээ нь 60-70 см, гүйлтийн хурд минутад 165-180 алхам, хэмжээ нь 80-90 см байна. Алхааг жагсаалын ба аяны гэж ангилна.

Жагсаалын алхааг салбарууд ёслолын жагсаалаар явж өнгөрөх, терийн хиндэтгэл ижиллэх, албан хаагч жагсаалаас гарах, захирагч /дарга/-д очих ба буцах, жагсаалд орох тэрчлэн жагсаалын бэлтгэлийн ёд хэрэглэнэ. Аяны алхааг дээр дурьдсанаас бусад тохиолдолд хэрэглэнэ. Харин хол зайд газар орныг туулах, албан хаагчийн байрлал (амрах байр), танхим дотор жагсаалаар явах ёд чөлөөтэй алхаж болно.

6. Жагсаалын алхааг “**Жагсаалын алхаагаар алхаад-МАРШ**” командаар эхэлнэ. Анхааруулах командаар биеэ бага зэрэг урагш болгон биеийн жинг баруун хөл дээрээ шилжүүлэн тэнцвэрээ хадгалж, гүйцэтгэх командаар зүүн хөлөө бүтэн алхаж хөдөлгөөнөө эхэлнэ.

Жагсаалын алхаагаар алхахдаа хөлөө эгцлэн елмийг жийж, газраас дээш 15-20 см өргөж, улаар нь газарт чанга тавьж, гараа хойш нь чөлөөтэй хаяж явна.

Гараа хаяхдаа тохойг нугалж, хагас атгасан гарыг китель /ёслол, албаны/-ийн хоёрдугаар товчны харалдаа, биенээс урагш атгасан гарын хэмжээний зайтай байхаар тогтоон барьж, гэдрэг нь мөрний үенд тултал хаяна. Тохойг, атгасан гарын түвшинд өргөж, биеэ эгцлэн чигээрээ харж алхана. /Зураг 4/

7. Аяны алхааг “**Алхаад-МАРШ**” командаар эхэлнэ. Энэ командаар эхний 2-3 алхамыг жагсаалын алхаагаар алхаж цаашид ердийн алхаанд шилжиж гараа чөлөөтэй хаяж, хөлөө олж явна.

Аяны алхаагаар алхах үед “**АНХААР**”, “**НОМХОН**” команд өгөх буюу салбарын нэр заах үед жагсаалын алхаанд шилжинэ. “Анхаар” командыг зөвхөн “**ЗОГС**” командын өмнө өгнө. “**НОМХОН, Зэрэгц-БАРУУН ТИЙШ (ЗҮҮН ТИЙШ, ДУНДАА)**” команд өгсөн үед гар хаяхгүй.

8. Гүйлтийг “**Гүйгээд-МАРШ**” командаар эхлэх бөгөөд биеийг ялимгүй урагш болгон хоёр гараа хагас нугалж, тохойгоо бага зэрэг гэдрэг татна. Гүйцэтгэх

командаар зүүн хөлөөс гүйлтийг эхлэн, гараа гүйлтэд тохируулан хаяна. Гүйлтээс алхаанд шилжихэд “Алхаад-МАРШ” команд өгнө.

9. Байран дээрх алхааг “Дороо алхаад-МАРШ”, хөдөлгөөний үед “ДООО” командаар гүйцэтгэнэ. /Зураг 5/

“ЧИГЭЭРЭЭ” командыг зүүн хөлийг газарт тавингуут өгөх бөгөөд баруун хөлөө байран дээрээ нэг алхаж зүүн хөлөөс эхлэн бүтэн алхаж хөдөлгөөнөө эхэлнэ. Энэ үед эхний 2-3 алхамыг жагсаалын алхаагаар гүйцэтгэнэ.

10. Хөдөлгөөнийг зогсоохын тулд “ахлагч Баатар - Зогс” команд өгнө. Гүйцэтгэх командаас хойш дахин нэг алхаж хөлөө хавсран жагсаалын үндсэн зогсолтод шилжинэ.

11. Хөдөлгөөний хурдыг өөрчлөхийн тулд “ГҮЙГЭЭД”, “УДААН АЛХААД”, “ХАГАС АЛХААД” команд өгнө.

12. Албан хаагчийг хажуу тийш шилжүүлэх, урагш буюу гэдрэг алхуулахын тулд алхамын тоог зааж дараахь командыг өгнө. Жишээ нь: “Ахлагч Баатар баруун (зүүн) тийш хоёр алхаад-МАРШ” командаар албан хаагч нь алхам бүрийн дараа хөлөө хавсран баруун (зүүн) тийш хоёр алхана. Урагш буюу гэдрэг алхуулахын тулд “Гурав алхаад-МАРШ” буюу “Гэдрэг хоёр алхаад-МАРШ” команд өгнө. Энэ командаар хөдөлгөөнийг зүүн хөлөөс эхэлнэ. Баруун (зүүн) тийш, гэдрэг алхахдаа гар хаяхгүй.

Явдал дунд эргэх

13. Явдал дунд эргэлтийг “Баруун (зүүн) тийш-ЭРГЭ”, “Эргээд-МАРШ” командаар гүйцэтгэнэ. Баруун (зүүн) тийш эргэх үед, гүйцэтгэх командыг баруун (зүүн) хөл газарт тавингуут өгнө. Энэ командаар зүүн (баруун) хөлөө нэг алхаж, зүүн (баруун) хөлийнхөө өмнө дээр эргэмэгц, баруун (зүүн) хөлийг урагш тавин алхана. Эргэхэд гүйцэтгэх командыг баруун хөлийг газар тавингуут өгнө. Энэ командаар зүүн хөлөө бүтэн алхаж, баруун хөлөө зүүн хөлнөөсөө ялимгүй зүүн тийш хагас алхаж, зүүн гараа дагаж хоёр хөлийн өмнө дээр огцом эргэн, зүүн хөлөөс эхлэн хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ. Эргэхдээ биеийг цэх байлгаж, эргэх үед гар хаяхгүй. Дороо алхах үед “Эргээд-МАРШ” командыг өгч болно.

14. Гүйж яваа үед баруун (зүүн) тийш эргэх болон бүтэн эргэлтийг алхах үеийнхтэй адил командаар гүйлтийн аясад тохируулан гүйцэтгэнэ.

15. Жагсаалын ажиллагааг өөрчлөх, зогсоохын тулд “ОРХИ” команд өгнө. Энэ командаар анхааруулах, гүйцэтгэх командын гүйцэтгэлийг зогсоож, уг командыг гүйцэтгэхийн өмнөх командад шилжинэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Дөрөв. Ёсолж хүндлэх, жагсаалаас гарах болон жагсаалд орох, захирагч /дарга/-д очих, буцах ажиллагаа

Байран дээрээ болон хөдөлгөөн дунд ёсолж хүндлэх

1. Ёсолгоо нь албан хаагчдын харилцааны соёл, бие биеэ харилцан хүндэтгэж байгаагийн илэрхийлэл мөн. Албан хаагчид нь ёсолгоог жагсаалын үндсэн зогсолт, хөдөлгөөний хувилбарыг чанд баримталж, зөв гүйцэтгэнэ.

2. Албан хаагч нь ёсолгоог баруун гарын хуруунуудыг нийлүүлэн алгаа тэнийлгэн доош харуулж, эрхий хурууг хагас нугалан түгжиж, дунд хурууг чамархайд хүргэн, тохойг мөрний өндөртэй харалдаа шугамд байхаар ергэж гүйцэтгэнэ. Хараа гаргахад гарын байрлал өөрчлөгдөхгүй. /Зураг 6/

3. Жагсаалын гадна албан хаагч нь өөр хоорондоо зерж өнгөрөх ёдээ ёсолж хүндлэхийн тулд 3-4 алхам ойртмогц “Номхон” болж, хараа гарган ёслох ба зерж өнгөрөмөгц ёсолгоогоо буулган хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ. Гүйцэж түрүүлэх үед зэрэгцэж ирмэгц “Номхон” болж ёслох, хоёр дахь алхамаас ёсолгоог буулгана. Хэрэв албан хаагчид ахлах дарга ойртон ирвэл түүний зүг эргэж ёсолно.

4. Албан хаагчид жагсаалын нэгдсэн ажиллагаанаас бусад үед малгайгүй ёсолж, харилцан хүндэтгэл үзүүлнэ.
5. Албан хаагчид өөр хоорондоо харилцахдаа “онцгой байдлын” гэсэн цолны өмнөх албаны нэршлийг хэрэглэхгүй байж болно. Харин нэгдсэн ажиллагааны үеийн илтгэл өгөхөд албаны нэршлийг хэрэглэнэ.

*Жагсаалаас гарах болон жагсаалд орох,
захирагчид очих буюу буцах*

6. Албан хаагчийг жагсаалаас гаргахын тулд дараах команд өгнө. Жишээ нь: “ахлагч Баатар жагсаалаас-ГАР”, эсхүл “ахлагч Баяр-НАД УРУУ (гүйгээд)”

Албан хаагч нэрээ сонсмогц “Би” гэх ба харин гарах /дуудах/ командаар “Гүйцэтгэе” гэж хариулна. Нэгдүгээр командаар албан хаагч нэгдигээр эгнээнээс эхлэн жагсаалын алхаагаар 3 алхам жагсаалаас гарч, жагсаал руу эргэж зогсоно. Хоёрдугаар командаар албан хаагч нэгдигээр эгнээнээс 1-2 алхам урагш гарч, явдал дундаа даргын зүг эргэж дөт замаар жагсаалын алхаагаар эсхил гийж, тийнд 2-3 алхам дөхөж очоод ирсэн тухайгаа илтгэнэ.

Жишээ нь: “Эрхэм ахлах дэслэгчид. Таны тушаалаар ахлагч Болд ирлээ”.

Албан хаагч хоёрдугаар эгнээнээс гарахын тулд зүүн гараараа урдаа зогсож байгаа албан хаагчийн зүүн мөр дээр зөөлөн тавихаар тэр нь зүүн хөлөөрөө урагш нэг алхаж, баруун хөлөө хавсралгүй хажуу тийш нь алхаад, зүүн хөлөө хавсарч жагсаалаас гарч буй алба хаагчийг өнгөрсөгөөд байрандаа орж зогсоно. Энэ ажиллагааг нэгдүгээр эгнээний баруун үзүүрийн албан хаагч баруун хөлөөс эхлэн гүйцэтгэнэ. Урагш алхахдаа гараа хаяж, гэдрэг алхахдаа гар хаяхгүй. Албан хаагч нэгдигээр эгнээнээс гарвал тийний байрыг ард нь зогсож байсан албан хаагч эзэлнэ.

Албан хаагч хоёр, гурав (дөрөв...)-ын цуваанаас гарахдаа аль дөт тал уруу урьдчилан баруун /зүүн/ тийш эргэж гарна. Хэрэв жагсаалаас гарах талд нь албан хаагч зогсож байвал тэр нь гэдрэг нэг алхаж /зүүн хөл/ өгөө хөлөө татаж хавсраад жагсаалаас гарч байгаа албан хаагчийг өнгөрсөгөөд байрандаа буцаж орно. Жагсаалаас гарсан албан хаагч явдал дундаа эргэж нэгдигээр эгнээнээс 3 алхам гарч жагсаал уруу эргэж зогсоно. Хэрэв дарга дуудсан бол шууд тийний зигт очиж илтгэнэ.

7. Албан хаагчийг жагсаалд эргүүлэн оруулахын тулд дараах команд өгнө. Жишээ нь: “Ахлагч Баатар-ЖАГСААЛД ОР”, эсхил зөвхөн “ЖАГСААЛД ОР”, “Ахлагч Баатар” командаар албан хаагч даргын зиг эргэж “Би” гэж хариулна. Харин “ЖАГСААЛД ОР” командаар ёсолж “Гүйцэтгэе” гэж хариулаад эргэж эхний алхалт (хөлийн улыг газар бүтэн тавих)-аар гараа буулгаж жагсаалын алхаагаар дөт замаар жагсаалд орно.

8. Жагсаалын гадна захирагч /дарга/-д очих ёд албан хаагч нь 4-5 алхам зайд жагсаалын алхаанд шилжиж 2-3 алхам зайд дөхөж очоод зогсонгуут ёсолж ирсэн тухайгаа илтгэнэ. (6-р заалт). Илтгэж дуусмагц гараа буулгана.

9. Албан хаагч захирагч /дарга/-аас буцах ёд явах зөвшөөрөл авмагц “Гүйцэтгэе” гэж хариулаад явах зиг эргэж, эхний алхаа (хөлийн улыг газар бүтэн тавих)-тай хамт гараа буулган, жагсаалын алхаагаар 2-3 алхаад аяны алхаанд шилжинэ.

10. Захирагч /дарга/ нь албан хаагчийг жагсаалд оруулах команд өгөх, эсхил тийнд явах зөвшөөрөл өгөхдөө ёсолж, дараа нь буулгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тав. Анги, салбарын явган жагсаал

1. Анги, салбарын дэлгээ жагсаал нэг буюу хоёр /түүнээс дээш/ эгнээ байж болно. Анги, салбарыг нэг (хоёр, гурав, дөрөв...) эгнээгээр жагсаахдаа “Анги, салбар нэг (хоёр, гурав, дөрөв...) эгнээ-ЖАГС” команд өгнө. Захирагч жагсаалын

үндсэн зогсолтоор зогсож, команд өгөөд жагсах зүгт харж зогсоно. Жагсангуут дарга нь жагсаалаас 2-3 алхам гарч жагссан байдлыг хянана. Дөрөв түүнээс цөөн хүнтэй тохиолдолд ямагт нэг эгнээ жагсана.

2. Анги, салбарыг байран дээр нь зэрэгцүүлэх шаардлагатай бол “ЗЭРЭГЦ” эсхүл “Зүүн тийш-ЗЭРЭГЦ” команд өгнө. “ЗЭРЭГЦ” командаар баруун үзүүрийнхээс бусад нь баруун тийш толгойг эргүүлж (баруун чих нь зүүн талынхаасаа дээгүүр, эрүү ергөн) өөрийгөө нэг гэж тоолоод дөрөвдэх хиний цээжийг харж байхаар зэрэгцэнэ.

“Зүүн тийш-Зэрэгц” командаар зүүн үзүүрийнхээс бусад нь толгойг зүүн тийш эргүүлж жагсаалаа журамлан /тогтоосон зай авч/ зэрэгцэнэ. Зэрэгцээний дараа “Номхон” командаар албан хаагчид толгойг эгцэлнэ.

3. Албан хаагчид нь “Болно”, “Сул-Зогс”, “Болно-Зас” командыг энэ дүрмийн 3 дахь хэсгийн 3.2-д заасны дагуу байран дээрээ гийцэтгэнэ. Албан хаагчид нь “Анги, салбар- ТАРААД” командаар тарж, “Анги, салбар-Жагс” командаар гийж цугларан жагсана.

4. Анги, салбараар гүйцэтгэх эргэлтүүдийг энэ дүрмийн 3 дахь хэсгийн 3.5, 3.14-д заасан журам, командаар биелүүлнэ.

5. Анги, салбарыг байран дээр нь салгахын тулд “Анги, салбар баруун тийш (зүүн тийш, дундаас)...алхам-САЛ (гийгээд - сал) команд өгнө. Гийцэтгэх командаар эхний буюу нэр заагдсан албан хаагчаас бусад нь заасан зүгт эргэн хөлөө хавсрангуут жагсаалын өвөр тал уруу толгойгоо эргүүлж, ардаа яваа албан хаагчийг мөрөн дээгүүрээ хянаж хурдавчилсан алхаагаар алхана. Ардах хинээ зогссоны дараа нэг алхах буюу командад заасан тоогоор алхаад зогсож, командгүйгээр зүүн (баруун) тийш эргэнэ.

Дундаас салах ёд нэр заагдсан албан хаагч “Би” гэж хариулаад зүүн гараа урагш нь өргөөд буулгана. Салгасан ёд байран дээр зэрэгцүүлэхэд хоорондын завсар хэвээрээ илдэнэ.

6. Нийлүүлэхийн тулд “Анги, салбар баруун тийш (зүүн тийш, дундаас)-НИЙЛ” команд өгнө. Гийцэтгэх командаар нэр зааснаас бусад албан хаагч нийлэх зүгт эргэсний дараа хурдавчилсан алхаагаар алхаж хураангуй жагсаалын тогтоосон зайг аван зогсож командгүйгээр баруун (зүүн) тийш эргэнэ.

7. Анги, салбарыг хөдөлгөөн үйлдүүлэхдээ “Алхаад (жагсаалын алхаагаар алхаад, гийгээд) - МАРШ” команд өгнө. Хэрэв шаардлагатай бол хөдөлгөөний чиглэл, зэрэгцэх зүгийг командад зааж өгнө. Жишээ нь “Анги, салбар-тийм чигт, баруун (зүүн) тийш зэрэгцэж алхаад-МАРШ”

“МАРШ” командаар бид албан хаагч зэрэгцээ, хоорондын завсар, зайг хадгалан нэг зэрэг хөдөлгөөнөө эхэлнэ.

Хэрэв зэрэгцэх зүгийг заагаагүй бол толгойг эргүүлэхгүй баруун тал уруу зэрэгцэнэ. Анги, салбар (билэг)-г зогсоохын тулд “Анги, салбар (билэг) - Зогс” команд өгнө.

8. Жагсаалыг хажуу тийш нь шилжүүлэхийн тулд “Анги, салбар баруун (зүүн) тийш-ЭРГЭ” команд өгч эргүүлээд “...алхам алхаад-МАРШ” команд өгнө. Албан хаагчид заасан тоогоор алхангуут “Зүүн (баруун) тийш-ЭРГЭ” команд өгч анхны байдалд оруулна. Түүнээс гадна энэ дүрмийн 3 дугаар хэсгийн 13-д зааснаар анги, салбарыг хажуу тийш болон урагш, гэдрэг алхуулж болно.

9. Анги, салбарыг хөл олуулж алхуулах шаардлагагүй тохиолдолд “Сул алхаад” команд өгнө. Албан хаагчдыг сул алхаанаас аяны алхаанд шилжүүлэх эсхил жагсаалд тэдний хөлийг олуулж алхуулахын тулд “ХӨЛӨӨ ОЛ” эсхил “ДӨРӨӨ” команд өгнө.

“ХӨЛӨӨ ОЛ” командаар чиглүүлэгч буюу жагсаалын эхний хинтэй алхаагаа нийлүүлнэ. Харин “ДӨРӨӨ” команд өгч, хөлөө олмогц “ЧИГЭЭРЭЭ” командаар аяны алхаагаар алхуулна.

10. Анги, салбарын чиглэлийг өөрчлөхийн тулд “Салбар баруун (зүүн) мөр түүрүүлж алхаад-МАРШ”(хөдөлгөөн дунд – “Баруун (зүүн) мөр түүрүүл”) команд өгнө.

Энэ командаар анги, салбар нь баруун (зййн) мєрєє тйрййлж алхана. Мєр тйрййлж буй албан хаагч хараа гарган бусдыгаа шахахгйгээр бйтэн алхаагаар алхана. Нєгєє үзййрийн албан хаагч нь дороо алхаж тйрййлж яваа албан хаагчтай хєдєлгєєнєє тохируулан алгуурхнаар зййн (баруун) тийш эргэнэ. Бусад албан хаагч тйрййлж байгаа үзййрийн зйг хараа гарган зэрэгцээ алдахгуй, нєгєє талынхаа зэрэгцсэн хйнтэй тохойгоор шйргэж алхаагаа тохируулан эргэнэ.

Анги, салбарын үзййр шаардлагатай хэмжээнд хйртэл мєр тйрййлмэгц “ЧИГЭЭРЭЭ” команд єгнє.

11. Анги, салбарыг нэг эгнээ жагсаалаас хоёр /тйүнээс дээш/ эгнээ болгон жагсаахын тулд урьдчилан “нэг-хоёрор /тйүнээс дээш эгнээний тоо/-оор ТООЛ” команд єгнє. Энэ командаар баруун йзййрээс эхлэн албан хаагчид дэс дараагаар зййн тийш хараа гарган єсрийнхєє тоог эхлэнгййт толгойг огцом эгц болгоно. Зййн йзййрийн тєгсгєлийн хйн хараа гаргахгйй. Мєн ийм журмаар нийтэд нь тоолуулахын тулд “дэс дараагаар-ТООЛ” команд єгнє. Хоёр эгнээ жагсаалд хоёр дугаар эгнээний зййн йзййрийн албан хаагч тоолж дуусмагц “Жагсаал дййрэн” эсхйл “Жагсаал...-р дутуу” гэж илтгэнэ.

12. Анги, салбарыг нэг эгнээ жагсаалаас хоёр /тйүнээс дээш/ эгнээ болгон жагсаахдаа нэг, хоёр /тйүнээс дээш эгнээний тоо/-оор тоолуулсаны дараа “хоёр /тйүнээс дээш эгнээний тоо/ эгнээ-ЖАГС” команд єгнє. Гййцэтгэх командаар “нэг” гэж тоолсон албан хаагч байрандаа, “хоёр” гэж тоолсон албан хаагч нэг алхам, “гурав” гэж тоолсон албан хаагч хоёр алхам, “дєрєв” гэж тоолсон албан хаагч гурван алхам гэх мэтчилэн эгнээ хоорондын зайг авч зййн хєлөөс эхлэн гэдрэг алхаж урд эгнээний албан хаагчийн шилийг харахын тулд баруун /зййн/ хєл хавсарч баруун тийш зай шахаж алхаад, зййн хєлєє хавсарч үндсэн зогсолтод шилжинэ.

13. Хоёр эгнээ хураангуй жагсаалаас байран дээр нь нэг эгнээ жагсаахын тулд урьдчилан нэг алхам салгаж, дараа нь “нэг эгнээ-ЖАГС” команд єгнє.

Гййцэтгэх командаар “хоёр” гэж тоолсон албан хаагчид зййн хєлєє зййн тийш алхаж, баруун хєлєє хавсралгййгээр урагш алхаад, зййн хєлєє татан хавсарч нэгдйгээр эгнээнд зэрэгцэн зогсоно.

Аяны жагсаал

14. Анги, салбарын аяны жагсаал нь нэг буюу хоёр /тйүнээс дээш/-ын цуваагаар байж болно. Анги, салбар жагсаахдаа “Нэг (хоёр...)-ийн цуваагаар - Жагс” команд єгнє. Дєрєв тййнээс цєєн бйрэлдэхййнтэй үед ямагт нэгийн цуваагаар жагсана.

15. Анги, салбарыг дэлгээ жагсаалаас цуваанд оруулахдаа “Баруун тийш-Эргэ” команд єгнє. Эргэмэгц захирагч /дарга/ нь баруун тийш хагас алхана.

16. Цуваанаас дэлгээ жагсаалд оруулахдаа “Зййн тийш-Эргэ” команд єгнє. Эргэмэгц захирагч /дарга/ нь урагш хагас алхана.

17. Нэгийн цуваанаас хоёр /тйүнээс дээш/-ын цуваанд оруулахдаа “Хоёр /гурав.../-ын цуваагаар алхаад марш” команд єгнє. Гййцэтгэх командаар захирагч /дарга/ нь голлон алхаж “нэг” гэж тоологчид байрандаа, “хоёр” гэж тоологчид нэг алхам, “гурав” гэж тоологчид хоёр алхам, “дєрєв” гэж тоологчид гурван алхам гэх мэтчилэн баруун тийш гарч цуваанд байраа эзэлж зай шахаж алхах буюу “Чигээрээ” эсхйл “Зогс” команд єгєх хйртэл хагас алхана.

18. Хоёрын цуваанаас нэгийн цуваанд оруулахдаа “нэгийн цуваагаар алхаад-МАРШ” команд єгнє. Хєдєлгєєн дунд “анги, салбар нэгийн Цуваанд” гэж командлана.

Гййцэтгэх командаар дарга нь бйтэн бусад нь хагас алхаж байр чєлєєтэй болмогц “хоёр” гэж тоологчид нэгдйгээрийн хойноос цуваанд орж хєдєлгєєнєє бйтэн алхаагаар йргэлжлййлнэ.

19. Анги, салбараас дээших нэгжидийг зэрэгцүүлэх, эргэлтдийг гийцэтгэх, жагсаалын хувирал болон бусад ажиллагаа нь нэгэн адил журам, командаар гийцэтгэнэ. Харин аяны жагсаал нь гурав, дөрөв тийнээс олон байж болно.

20. Хэрэв анги, салбарыг машинтай жагсаах шаардлага гарвал машинууд нь жагсаалын сгийн эгнээнээс хойш 2 метрийн зайд нэг шугамд байрлах буюу зайг ахлах захирагч /дарга/-аас тогтооно.

Байран дээрээ болон хөдөлгөөн дунд жагсаалаар ёсолж хиндэтгэх

21. Анги, салбарын захирагч /дарга/ нь ахлах даргыг угтан ёсолж хиндэтгэхийн тулд тийнийг 10-15 /40-50/ алхам ойртон ирмэгц “Анги (салбар) номхон, зэрэгц-Баруун тийш (зүүн тийш, дундаа)” команд өгнө.

Энэ командаар жагсаалд байгаа бие биеэрлэхийн жагсаалын индсэн зогсолтод шилжин даргыг баруун (зүүн) тийш хараа гаргаж, дагуулан харах бөгөөд жагсаалд байгаа дарга, захирагч нар команд өгмөгц зэрэг ёсолно.

22. Анги, салбарын захирагч /дарга/ команд өгөөд ёсолж, ахлах дарга уруу жагсаалын алхаагаар очиж, тийнээс 2-3 алхам зайд зогсож илтгэнэ. Жишээ нь: “Эрхэм хурандаад: Салбар илзлэгт бэлэн жагссан. Салбарын дарга, онцгой байдлын ахмад Цогт”,

“Эрхэм хурандаад: Аврах тусгай анги илзлэгт бэлэн жагссан. Ангийн захирагч, онцгой байдлын хурандаа Даваа”.

Жагсаал хилээн авч байгаа дарга нь команд өгч байгаа захирагч /дарга/-ийг ёсолмогц нэгэн адил ёсолж илтгэл авна. Дарга илтгэл өгөөд ёсолсон гараа буулгалгүй зүүн (баруун) хөлөө хажуу тийш алхан баруун (зүүн) тийш эргэж, даргыг өнгөрүүлээд тийний араас 1- 2 алхам зайд жагсаалын гадна талд хөл нийлүүлэн (жагсаалын алхаагаар) дагаж алхана. Даргыг явж өнгөрсний дараа эсхил тийний “БОЛНО” командаар захирагч /дарга/ “БОЛНО” команд өгөөд ёсолгоог буулгана.

23. Жагсаалаар явах ёд ёсолж хиндлэхийн тулд захирагч /дарга/ нь даргад 10-15 алхам ойртмогц “Анги, салбар номхон зэрэгц (зэргээц) - баруун тийш (зүүн тийш)” гэж команд өгнө. “Номхон” командаар албан хаагчид бигд жагсаалын алхаанд шилжиж “Зэрэгц-Баруун тийш (зүүн тийш)” командаар даргын зиг нэг зэрэг хараа гарган гар хаялтыг зогсооно. Команд өгөх ёд жагсаалд байгаа захирагч /дарга/ нар энэ дүрмийн 4 дүгээр хэсгийн 2 дахь заалтад заасан журмын дагуу ёсолно. Даргыг өнгөрөөгөөд эсхил тийний “Болно” командаар анги, салбарын дарга “Болно” команд өгч ёсолгоог буулгана.

Жагсаалаар дуулж яваа үед ёсолж хүндлэх команд өгмөгц дуулахаа зогсооно.

24. Захирагчийг мэндлэх эсхүл баяр хүргэх үед албан хаагчид чанга тод дуугаар нэгэн зэрэг хариулна. Жишээ нь: “Эрхэм хурандаагийн амрыг эрье” эсхүл “Ура, ура, ура”

Хөдөлгөөн дунд албан хаагчид хариултыг зүүн хөлийг тавингуут эхэлж, дараагийн үгийг хөл тавих бүрт хэлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Зургаа. Ёслолын жагсаал

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр Төрийн болон цэргийн онцгой үйл явдлыг тэмдэглэн өнгөрүүлэхийн тулд онцгой байдлын анги, салбар ёслолын жагсаалд оролцоно.
2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга ёслолын жагсаалд оролцох бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, хувцас хэрэглэл, анги, салбар жагсах журмыг тогтооно.
3. ёслолын жагсаалд оролцох анги, салбар заасан газарт байраа эзэлж, удирдлага нь анги, салбарынхаа баруун гарт нэг эгнээ жагсана. Тэднээс зүүн тийш 2 алхам завсартай анги, салбарын тугч, туг хамгаалагчид жагсана.

4. Хөгжмийн удирдаачийн мэдэлд хөгжимчид нэгдэж жагсана.
5. Ёслолын жагсаал командлагч жагсаал хүлээн авагчид илтгэл өгөх үед, түүнчлэн ёслолын жагсаалаар явж байгаа анги, салбарын туганд жагсаалын гадна байгаа алба хаагчид жагсаалын үндсэн зогсолтод шилжиж, ёсолж хүндэтгэнэ.

Ёслолын жагсаал командлагч,
ёслолын жагсаал хүлээн авагчийг угтах

6. Ёслолын жагсаал командлагчийг угтахдаа ёслолын жагсаалд оролцож байгаа анги салбарын захирагч /дарга/ нарын ахлах нь “ЗЭРЭГЦ”, “НОМХОН”, “ЗЭРЭГЦ, БАРУУН ТИЙШ /ЗҮҮН ТИЙШ, ДУНДАА” команд өгөөд ёслолын жагсаалд оролцох бүрэлдэхүүн бэлэн жагссан тухай илтгэнэ. Ёслолын жагсаал командлагч илтгэл хүлээн аваад “БОЛНО” команд өгнө. Ёслолын жагсаал командлагчийг угтах үед хөгжим тоглохгүй
7. Ёслолын жагсаал хүлээн авагчийг жагсаалд 40-50 алхам ойртон ирмэгц ёслолын жагсаал командлагч ёслолын жагсаал хүлээн авагчийг угтахдаа “Ёслолын жагсаал, НОМХОН”, “Зэрэгц, БАРУУН ТИЙШ /ЗҮҮН ТИЙШ, ДУНДАА” гэж команд өгнө. Салааны захирагч болон түүнээс дээших тушаалын бүх захирагч /дарга/ нар ёсолж, хөгжимд “Угтах марш” эгшиглэнэ.
8. Ёслолын жагсаал командлагч ёсолж, ёслолын жагсаал хүлээн авагчийг угтан очиж илтгэл өгнө. Жишээ нь: “Эрхэм хурандаад /Эрхэм сайдад/..... нийслэлийн хүрээний анги, салбарууд Онцгой байдлын алба үүсч хөгжсөний ... жилийн ойн ёслолын жагсаалд бэлэн жагссаныг илтгэе. Ёслолын жагсаал командлагч, онцгой байдлын хурандаа Очирын Баатар”.
9. Ёслолын жагсаал командлагч илтгэл өгөхөөр зогсмогц хөгжим тоглолтоо зогсооно. Ёслолын жагсаал командлагч илтгэл өгч дуусаад ёсолсон гараа буулгалгүйгээр ёслолын жагсаал хүлээн авагчийн араас жагсаалын гадна талд дагаж явна.
10. Ёслолын жагсаал хүлээн авагч илтгэл авсны дараа жагсаалын урдуур явж, албан хаагчидтай мэндлэн баяр хүргэнэ. Энэ үед хөгжимд “Угтах марш” эгшиглэнэ. Ёслолын жагсаал хүлээн авагч мэндлэн, баяр хүргэхээр зогсох үед хөгжим тоглолтоо түр зогсооно.
11. Мэндчилж баяр хүргэхэд анги, салбарууд “Дотоод албаны дүрэм”-д зааснаар хариу мэндчилж гурвантаа “Ура” цуурайтуулна.
12. Ёслолын жагсаал хүлээн авагчийг мэндлээд буцаж индрийн дэргэд очтол анги, салбарууд тасралтгүй уртаар “Ура” цуурайтуулна.
13. Ёслолын жагсаал хүлээн авагч индэр дээр гарах хүртэл хөгжимд “Хүндэтгэлийн аялгуу” тоглоно.
14. Ёслолын жагсаал хүлээн авагчийн командаар ёслолын жагсаал командлагч “БОЛНО” команд өгөхөд захирагч /дарга/ нар ёсолгоог зэрэг буулгана.
15. Дараа нь ёслолын жагсаал хүлээн авагч үг хэлнэ. Үг хэлж дуусмагц анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүн гурвантаа “Ура” цуурайтуулахад хөгжимд Монгол Улсын “Төрийн дуулал” эгшиглэнэ. Салааны захирагч, түүнээс дээших албан тушаалтан ёсолж, “Төрийн дуулал” эгшиглэж дуусмагц бүгд ёсолгоог буулгаж, жагсаалын үндсэн зогсолтод шилжинэ.
Ёслолын жагсаалаар явж өнгөрөх
16. Ёслолын жагсаал командлагч анги, салбаруудыг ёслолын жагсаалаар явуулахдаа “Ёслолын жагсаал, НОМХОН”, “Жагсаалын алхаагаар, салбар салбар /анги/-аар, салбаруудын /анги/-уудын хооронд ... алхамын зайтай, Онцгой байдлын албаны туг чигээрээ, бусад нь баруун тийш Эргэ, баруун /зүүн/ тийш зэрэгцэж жагсаалын алхаагаар алхаад-Марш” команд өгнө.
17. “Жагсаалын алхаагаар” командаар салбар /анги/, салааны захирагч нар өөрсдийн салбарын өмнө, анги, салбарын захирагч, түүний орлогч нар, тугч, туг

хамгаалагчид эхний салбарын захирагчийн урд тогтоосон зайд жагсаалаас гарч зогсоно.

18. “баруун /зүүн/ тийш зэрэгцэж” командаар энэ дүрмийн 6 дахь хэсгийн 17-д зааснаас бусад бие бүрэлдэхүүний баруун /зүүн/ үзүүрийнхээс бусад албан хаагчид баруун /зүүн/ тийш хараа гаргаж, жагсаалын алхаагаар алхах бөгөөд эхний 3 алхамын дараа харааг эгцэлнэ.

19. Ёслолын жагсаал командлагч команд өгөөд туг залагчийн өмнө 10 алхам зайд явж, ёслолын жагсаал хүлээн авагчид 10-15 алхамын зайд ойртмогц ёсолж, түүний зүг хараа гарган жагсаалын алхаагаар алхаж, ёслолын жагсаал хүлээн авагчаас өнгөрмөгц жагсаалаас гарч, түүний баруун хойд талд зогсоно.

20. Ёслолын жагсаал командлагчийн “МАРШ” командаар хөгжим тоглоход салбар /анги/-ууд хөгжмийн хэмнэлд тохируулан жагсаалын алхаагаар хөдөлгөөнөө эхэлнэ. “ЧИГЭЭРЭЭ” командаар тогтоосон зайг барьж, түрүүчийн салбар /анги/ араас алхана.

21. Ёслолын жагсаалаар явж өнгөрөх үед эхний салбар /анги/ нэгдүгээр эгнээнээс ангийн захирагч 12, түүний орлогч нар 9 /нэг эгнээгээр/, тугч, туг хамгаалагчид Онцгой байдлын албаны тугтайгаа 7, салбарын захирагч 4, салааны захирагч 2 алхам зайд тус тус алхана.

22. Ёслолын жагсаалыг хүлээн авагчид 15-20 алхамын зайд ойртмогц анги, салбарын ахлах захирагч /дарга/ нь “Салбар /анги/ НОМХОН, ЗЭРЭГЦ БАРУУН /зүүн/ ТИЙШ” команд өгч ёслон, түүний зүг хараа гаргахад, жагсаалд байгаа бүх бүрэлдэхүүний баруун /зүүн/ үзүүрийнхэн чигээрээ, бусад нь хараа гаргана. Салбар /анги/-ын захирагч /дарга/ ёслолын жагсаал хүлээн авагчаас 10 алхамын зайд өнгөрмөгц анги, салбарын ахлах захирагч /дарга/ нь “БОЛНО” команд өгч, ёсолсон гараа буулгахад албан хаагчид бүгд толгойгоо эгцэлнэ.

23. Тугч, туг хамгаалагчид ёслолын жагсаалаар явах үед хараа гаргахгүй.

24. Сүүлийн салбар /анги/-ын араас нэгдсэн хөгжмийн салаа явдал дундаа тоглолтоо үргэлжлүүлэн ёслолын жагсаалаар явна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Долоо. Анги, салбарын жагсаалын үзлэг

1. Жагсаалын үзлэгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газар, хэлтэс, харьяа нэгжийн бэлэн байдлын тившинг тодорхойлох, гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль явуулах, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын нэрэмжит үзлэг, Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит иж бүрэн болон биелэлтийн шалгалт, шаардлагатай бусад ёд явуулна.

2. Үзлэгээр албан хаагчдын гадаад їзэмж, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан хаагчийн хувцас өмсөх дүрмийн хэрэгжилт, бусад техник хэрэглэл, багаж хэрэгслийн бүрэн бїтэн байдлыг шалгана.

3. Жагсаалын үзлэгийг шууд захирах дарга буюу шалгалт, шалган зааварлах ажил удирдахаар томилогдсон захирагч /дарга/ явуулна. Үзлэг явуулах захирагч /дарга/ нь үзлэгт хамрагдах анги, салбарын захирагч /дарга/-д хэзээ, хаана явуулах, бие бүрэлдэхүүн ямар хувцастай жагсах, ямар техник хэрэгсэл, багаж хэрэгслийг үзлэгт гаргахыг мэдэгдэнэ.

4. Үзлэг хийхийн өмнө захирагч, дарга нар жагсаалын мэдээ /хоёрдугаар хавсралт/-г гаргасан байна.

5. Шаардлагатай гэж үзвэл ахлах дарга нь үзлэг явуулахаар томилогдсон албан тушаалтныг жагсаалын үзлэгийн өмнө тусад нь шугамд дуудан шалгаж болно.

6. Жагсаалын үзлэг хийх үед байгууллага, анги, салбарууд нь ихэвчлэн хоёр эгнээ дэлгээ жагсаалаар жагсах бөгөөд жагсаалын захирагч, дарга жагсаалыг голлон зогсоно. Жагсаалын үзлэг явуулах захирагч жагсаалд 20-30 алхам ойртон

ирэхэд анги, салбарын захирагч, дарга нь “Анги салбар, НОМХОН, зэрэгц-БАРУУН ТИЙШ (ЗҮҮН ТИЙШ, ДУНДАА)” команд өгнө. Анги, салбарын захирагч, дарга команд өгөөд ёсолж захирагчруу жагсаалын алхаагаар очиж, түүнээс 2-3 алхам зайд зогсож илтгэнэ. Жишээ нь: “Эрхэм дэд хурандаад, салбар жагсаалын үзлэгт бэлэн жагссан. Салбарын захирагч ахмад Баатар”

7. Илтгэж дуусаад анги, салбарын захирагч зүүн /баруун/ хөлөө хажуу тийш алхангуут баруун /зүүн/ тийш эргэж, захирагчийг өнгөрүүлээд хойноос нь 1-2 алхам зайд жагсаалын гадна талд түүнтэй хөл нийлүүлэн ёсолсон хэвээр дагаж алхана.

8. Хөгжимчид нь анги, салбарын захирагчийн “Зэрэгц-БАРУУН ТИЙШ /ЗҮҮН ТИЙШ, ДУНДАА” командаар “Аяны марш” тоглох бөгөөд түүнийг үзлэг хийх захирагчийн өмнө очиж зогсмогц тоглолтоо зогсоож, илтгэл өгсний дараа үргэлжлүүлнэ.

9. Үзлэг явуулах захирагч нь анги салбарын жагсаалын урдуур баруун үзүүрээс зүүн үзүүр хүртэл явж өнгөрөөд, эргэж жагсаалыг голлон зогсмогц хөгжимчид тоглолтоо зогсооно. Захирагч /дарга/ анги, салбарын бие бүрэлдэхүүнтэй мэндэлсний дараа “БОЛНО” команд өгөхөд анги, салбарын захирагч “БОЛНО” команд өгөөд ёсолсон гараа буулгаж үзлэг хийх захирагчид жагсаалын мэдээг гардуулсны дараа түүний өгсөн үүргийг биелүүлнэ.

10. Үзлэгээр бие бүрэлдэхүүний ирц, албан хаагчийн гадаад үзэмж, жагсаалын дүрмийн мэдлэг, хувийн бэлтгэл, бусад хэрэглэлийг шалгах ажиллагаанаас эхэлж, ёслолын жагсаалаар явж өнгөрөх ажиллагаагаар төгсөнө.

11. Үзлэгээр Онцгой байдлын байгууллагын болон жагсаалын дууг дуулах чадварыг шалгаж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Найм. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тугийг залж гаргах, жагсаалд байрлуулах, буцааж оруулах

1. Онцгой байдлын ерөнхий газар “Онцгой байдлын албаны”, аймаг, нийслэл, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, нийслэлийн Аврах анги нь тугтай байх бөгөөд туг залагч, тугч, туг хамгаалагч нарыг тушаалаар томилно. Тугийг залах ёд тїїнийг їргэлж дэлгээ байдлаар, харин хол зайд хөдөлгөөн їйлдэх їед гэрэнд хийж хадгалж авч явна. Тугч, туг хамгаалагчид мөрөвч, бүс, сэлэм, цагаан бээлий, аксельбанттай байх бөгөөд туг залагч, тугч, туг хамгаалагчид түрийтэй гутал, гутлын өмд /галефе/-тэй байна.

Тугийг жагсаалд авч явах байдал

2. Жагсаалд тугч тугийг баруун гараараа барьж цэх зогсоно. Тугийн ишний доод їзїїр нь баруун хөлийн гадна талд, улны дунд хэрд байна. /Зураг 7/

3. Тугч нь “Алхаад” анхааруулах командаар тугийг баруун гараар хазайлгалгїй ергөж, зїїн гараар ишийг нь тогтоогчид хийж, ёслолын жагсаалаар явж өнгөрөхөд бэлтгэнэ.

4. Туг залагч, тугч, туг хамгаалагч нь жагсаалд даргын орлогч нарын зїїн талд жагсана.

Тугийг залж гаргах, буцаан оруулах

5. Туг залагчийн “Тугч миний хойноос алхаад-МАРШ” командаар тугч, туг хамгаалагчид тогтоосон зай авч хагас алхаагаар хөдөлгөөнөө эхлэнэ. Энэ їед туг залагч, тїїний араас 3 алхам зайтай тугч, туг хамгаалагчдын хамт явна.

6. Захирагч /дарга/ тугийг жагсаалд 40-50 алхам ойртон ирмэгц “Анги, салбар Онцгой байдлын албаны тугийн дор (...тугийн дор)-Номхон, Зэрэгц-Баруун тийш (зүүн тийш, дундаа)” команд өгнө.

Энэ командаар салаа буюу тийнээс дээших салбарын захирагч нар ёсолж, бигд тугийн зиг хараа гарган дагуулж өнгөрсөнө.

Хөгжимд “Туг хиндэтгэх аялгуу” эгшиглэнэ. Тугч, туг хамгаалагчдын хамт туг залагчийн удирдлагын дор жагсаалын урдуур явж, жагсаалын эхэнд гармагц туг залагч тугчийг, туг хамгаалагчдын хамт байранд нь байрлуулсны дараа өөрөө удирдлагын бэрэлдэхинд байраа эзэлнэ. Тугчийг байраа эзэлмэгц хөгжим тоглолтоо зогсоох ба дарга /захирагч/ “Болно” команд өгнө.

7. Тугийг буцааж залахын тулд захирагч /дарга/ нь “Анги, салбар Онцгой байдлын албаны тугийн дор /...тугийн дор/-Номхон /энэ командаар туг залагч байраа эзэлж, тугч тугийг баруун гараар хазайлгалгүй өргөж, зүүн гараар ишийг нь тогтоогчид хийж ёслолын жагсаалаар явж өнгөрөхөд бэлтгэнэ/, Зэрэгц-Баруун тийш (зүүн тийш, дундаа)” команд өгөхөд хөгжимд “Туг хиндэтгэх аялгуу” эгшиглэнэ. Энэ ёд Туг залагч “Тугч миний хойноос алхаад- МАРШ” команд өгч тугийг залж хадгалах байр руу явна.

Тугч, туг хамгаалагчид жагсаалаас 20-30 алхам холдмогц хөгжим тоглолтоо зогсоож захирагч “БОЛНО” гэж командлана.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

1. Энэ дүрмээр зохицуулаагүй жагсаалын ажиллагааг “Цэргийн жагсаалын дүрэм”-д зааснаар ойлгоно.

2. “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн жагсаалын элемент”-ийн зургийг хавсралтаар батална.

_____ оОо _____

Онцгой байдлын асуудал
эрхэлсэн байгууллагын албан
хаагчийн жагсаалын дүрмийн
1-р хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН
ЖАГСААЛЫН ЭЛЕМЕНТ



Зураг 1. Жагсаалын үндсэн зогсолт



Зураг 2. “Болно” командаар зогсох байдал



Зураг 3. Малгай авсан байдал



Зураг 4. Жагсаалын алхаагаар алхах байдал



Зураг 5. Дороо алхах байдал



Зураг 6. Байран дээрх болон хөдөлгөөн дундах ёсолгоо



Зураг 7. Онцгой байдлын албаны тугийг жагсаалд авч явах байдал



Зураг 7¹. Ёслолын жагсаалаар явах үед
Онцгой байдлын албаны тугийг барих байдал

---o0o---

